



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/61

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.3, 3.1.3 дахь заалт, 2020 оны 75 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол оронд ардчилсан, шинэ Үндсэн хууль батлах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх, төрийн албыг төгөлдөржүүлэхэд бодит хувь нэмрээ оруулж, улс, аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд олон жилийн хөдөлмөр бүтээлээ зориулан идэвх зүтгэлтэй ажилласныг үнэлэн Монгол Улсын Хүний гавъяат эмч, Ардын Их Хурлын депутат асан Ж.Даваабал, Цэцэг сумын Баян-Овоо багийн Улсын аварга малчин, Ардын Их Хурлын депутат асан Ц.Баттулга, Манхан сумын харъяат, Монгол Улсын Гавъяат эдийн засагч, Ардын Их Хурлын депутат асан Ү.Цэдэнбал нарыг аймгийн дээд шагнал “Зуун эрхэм” шагналаар шагнахад тус бүр 100000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 300000 төгрөг/ Гурван зуун мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02-00069

Аймгийн Засаг даргын 2020 оны  
02 дугаар сарын 06-ны өдрийн  
А/61 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН “ЗУУН ЭРХЭМ” ШАГНАЛААР  
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Олгох шагнал
1	Ж.Даваабал	Хүний гавъяат эмч	100000
2	Ц.Баттулга	Улсын аварга малчин	100000
3	Ү.Цэдэнбал	Гавъяат эдийн засагч	100000
<b>Дүн</b>			<b>300000</b>